



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/306

Мандалговь

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.3, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан үйл ажиллагааг иргэд олон нийтэд хүргэх, хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор хэвлэл мэдээллийн эх бэлтгэгч, видео бичлэг эвлүүлэгчийн ажлыг 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.

2. Зардалд шаардагдах 8,000,000 (Найман сая) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван), Ерөнхий санхүүч (С.Адъяасүрэн) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

48 3100800